



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2017 оны 11 дугаар сарын 21

№ 01/84 УАГ-НАГ/2017/03-НА

Мандалговь хот

Г

Зөрчил арилгуулах тухай

Т

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2, 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д нийцлийн аудит хийх явцад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд 50 тендер төлөвлөгдсөнөөс эхний 3 улирлын байдлаар 31 тендер зарлагдаж нийт 87 компани оролцож материалыа ирүүлснээс 39 компани шалгарсан боловч шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг оруулаагүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3 дахь /тендериин баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендериин урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;/ заалтыг,

2. Засаг даргын хөрөнгө зарцуулах тухай захирамжаар **337,700,00.00** /Гурван зуун гучин долоон сая долоон зуун мянган/ төгрөгийг зарцуулах 12 шийдвэр гарсан боловч шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь /бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;/ заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбоодох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-дахь

/Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг маслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;/ заалтуудыг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын дагуу дээрх мэдээллүүдийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нөхөн байршуулах,
2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Албан шаардлагын биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 20-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дундговь аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/, ерөнхий санхүүч /С.Энхжаргал/ нарт даалгав.



АЛБАН ШААРДЛАГЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА
ЕРӨНХИЙ САНХҮҮЧ
О.БАТ-ЭРДЭНЭ
С.ЭНХЖАРГАЛ

АУДИТОР Т.ОЮУН-ЭРДЭНЭ

ЗАСАГ ДАРГА
ЕРӨНХИЙ САНХҮҮЧ

Т.ОЮУН-ЭРДЭНЭ
4817144213
ЗЮА0039 9033475

² Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлэгээгүй тохиолдолд зорчил гаргасан албан тушаалтанд ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна.